

ЧИ БОЛ МИНИЙ БААТАР!

Ковид 19-тэй тэмцэх
хүүхдүүдийн арга



IASC
Inter-Agency Standing Committee

“Чи бол миний Баатар” ном бүтсэн түүх

Энэхүү номыг “Inter-Agency Standing Committee” буюу дэлхий даяар хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохицуулж ажилладаг “Байгууллага хоорондын байнгын хороо (БХБХ)”-ны онцгой нөхцөл дэх сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг хариуцсан ажлын хэсгээс эрхлэн гаргав. Номыг бүтээх ажилд БХБХ-ны гишүүн байгууллагын олон улс, бүс, улс орон дахь мэргэжилтнүүд болон 104 орны хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш нар хувь нэмрээ оруулсан юм. Ковид-19-ийн дэгдэлтийн үед үүссэн хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд-нийгэм сэтгэлзүйн хэрэгцээг тодруулахаар Араб, Англи, Итали, Франц улсыг хамруулан судалгаа авч ажиллалаа. Судалгааны үр дүнд үндэслэн номын агуулга, түүхийг зохиосон ба Ковид-19 дэгдсэн хэд хэдэн орны хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нараас авсан саналыг оруулж, холбогдох сайжруулалтыг хийсэн билээ.

Ковид-19-ийг хэрхэн даван туулж байгаа тухайгаа дэлхийн олон орны 1,700 гаруй хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш нар сэтгэл гарган бидэнд хуваалцсан юм. Судалгаанд хамрагдаж, энэхүү түүхийг сайжруулахад тусалсан тэдгээр хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш нартаа гүнээ талархаж байна. Иймээс энэхүү түүх нь дэлхийн өнцөг булан бүрт суугаа хүүхдүүдийн өөрсдөө боловсруулсан, мөн хүүхдэд зориулсан түүх юм.

Номын зураг болон түүхийг бичсэн Хелен Патрикт БХБХ-ны онцгой нөхцөл дэх сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг хариуцсан ажлын хэсгийн зүгээс талархал илэрхийлье.

©БХБХ, 2020. Хэвлэлийг ашгийн бус Криэтив Коммон Атрибьюшний ShareAlike 3.0 IGO (CC BY-NC-SA 3.0 IGO; <https://creativecommons.org/licenses/by-nc-sa/3.0/igo>) зөвшөөрлөөр хэвлэв. Энэ зөвшөөрлийн хүрээнд холбогдох нөхцөлийн дагуу ашгийн бус зорилгоор орчуулж, хэвлэж болно.

Танилцуулга

“Чи бол миний Баатар” ном нь Ковид-19 цар тахал дэгдсэн дэлхийн өнцөг булан бүрт буй хүүхдэд зориулсан ном.

“Чи бол миний Баатар” номыг эцэг эх, асран хамгаалагч болон багш нар хүүхдэд ганцаарчлан эсвэл жижиг бүлгээр уншиж, ярьж өгнө. Номыг эцэг эх, асран хамгаалагч, багш нарын дэмжлэггүйгээр хүүхэд бие даан унших нь тохиромжгүй юм. Тус номыг дагалдаж Ковид-19-тэй холбоотой асуудлыг шийдэх, хүүхдэд зориулсан нэмэлт үйл ажиллагааг багтаасан “Баатруудад зориулсан Үйлдэл” зөвлөмж гаргахаар зэхээд байна.

Орчуулга

Номыг Араб, Хятад, Франц, Орос, Испани хэлрүү орчуулах ажлыг БХБХ-ны ажлын хэсэг зохион байгуулж байна. Бусад хэл рүү орчуулахтай холбоотой асуудлаар БХБХ-ны сэтгэцийн эрүүл мэнд-нийгэм сэтгэлзүйн дэмжлэг хариуцсан ажлын хэсгийн thpss.refgroup@gmail.com цахим хаягаар холбогдоно уу. Бэлэн болсон орчуулгыг нь БХБХ-ны ажлын хэсгийн цахим хуудсанд байршуулна. Хэрэв орчуулах бол дараах зүйлүүдийг анхаарна уу:

- Номонд байгууллагын ба хандивлагч байгууллагын лого байршуулахгүй.
- Текст, зураг өөрчлөх тохиолдолд БХБХ-ны логог ашиглахыг зөвшөөрөхгүй ба тухайн байгууллага, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг БХБХ-ны зүгээс зөвшөөрөхгүй
- Орчуулга болон өөрчлөлт хийх бол Криэтив Коммонсийн CC BY-NC-SA 4.0 or 3.0 зөвшөөрлийн журмын дагуу зөвшөөрөл авна уу. Холбогдох зөвшөөрлийн жагсаалтыг эндээс харна уу. <https://creativecommons.org/share-your-work/licensing-considerations/compatible-licenses>
- Орчуулсан номонд дараах мэдэгдлийг багтаана. Энэ нь “Энэхүү орчуулгыг БХБХ-ноос хийгээгүй ба орчуулгын агуулга, үнэн зөв байдалд БХБХ хариуцлага хүлээхгүй. Англи хэл дээрх эх хувилбар нь Байгууллага хоорондын байнгын хорооноос гаргасан “Миний Баатар бол Чи: Хүүхдүүд Ковид-19-тэй хэрхэн тэмцэх вэ?” ном болно. Тус номын хэвлэлд CC BY-NC-SA 3.0 IGO зөвшөөрөл хамаарна.”
- Энэхүү номыг Монгол хэлэнд хөрвүүлэх ажлыг Хүүхдийг Ивээх Сан хийсэн ба номын орчуулга, Монгол улсад түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой асуудлаар burenjargal.bombish@savethechildren.org хаягаар холбогдоно уу.





Сараагийн хувьд ээж нь энэ дэлхийн хамгийн сайн ээж төдийгүй хамгийн сайн эрдэмтэн учраас ээж нь түүний баатар. Гэтэл ийм мундаг ээж нь хүртэл корона вирусийг эдгээх аргыг мэдэхгүй.

“Ковид-19 гэж яг ямар зүйл юм бол?” гэж Сараа ээжээсээ асуулаа.

“Ковид-19 буюу корона вирус гэдэг нь бидэнд харагдахгүй өчүүхэн жижиг зүйл. Гэхдээ өвчтэй хүн ханиах, найтаахад хэн нэгэн хүнд юм уу эд зүйлсэд хүрэхэд тардаг. Өвдсөн хүмүүс халуурч, ханиаж, амьсгалахад хэцүү болдог.” гэж ээж нь хариулав.

“Бид нар энэ жижигхэн вирусийг харж чадахгүй байгаа болохоор тэмцэж чадахгүй байгаа юм уу?” гэж Сараа асуув.

“Бид тэмцэж чадна. Хамгийн гол нь чи аюулгүй байх хэрэгтэй. Энэ вирусээр олон төрлийн хүмүүс өвчилж байгаа болохоор хүн бүр үүнтэй тэмцэхэд туслах хэрэгтэй. Бүх хүүхдэд онцгой авьяас байдаг болохоор хүүхдүүд ч энэ вирусийг ялахад тус болж чадна. Бид бүгдийн төлөө чи аюулгүй байх нь маш чухал. Чи миний баатар болох хэрэгтэй.” гэж Сараагийн ээж хариуллаа.



Ээжтэйгээ ярилцсан тэр үдэш Сараа орондоо ороход өөрт нь огтхон ч баатар болсон юм шиг санагдсангүй. Сараа хичээлдээ явмаар байсан ч сургууль нь хаалттай, найзуудтайгаа уулзмаар байвч гадагшаа гарч болохгүй байлаа. Дэлхий ертөнцийг айлгаад байгаа корона вирусийг зогсоохыг Сараа маш их хүсэж байлаа.

“Баатруудад супер хүч чадал байдаг. Гэтэл надад ямар хүч байгаа юм бол?” гэж Сараа өөрөөсөө асуугаад нүдээ аниад зүүрмэглэжээ.


Гэнэт харанхуйгаас намуухан хоолой нэрийг нь дуудан шивнэж байна.

“Хэн бэ?” гэж Сараа хариу шивнэв.

“Сараа, баатар болохын тулд чамд юу хэрэгтэй вэ?” гэж өнөөх хоолой охиноос асуулаа.

“Өөрийгөө бас бусад хүмүүсийг энэ вирусээс яаж хамгаалах тухай дэлхийн бүх хүүхдэд дамжуулж хэлэх нэг зүйл хэрэгтэй байна...” гэж Сараа хариулав. “Тэгвэл би чамд яаж туслах вэ?” гэж өнөөх үл таних хоолой дахин асуув.

“Маш чангаар дуугардаг, нисэж чаддаг, бас тус болж чадах тийм нэг зүйл хэрэгтэй байна!” гэж Сараа хэллээ. Гэнэт сарны гэрэлд нэгэн гайхалтай зүйл цонхоор нь орж ирэв...





“Чи хэн бэ?” гэж Сараа гайхан асуув.

“Намайг Арио гэдэг.” гэж тэр хариуллаа.

“Арио, би чамайг өмнө нь хэзээ ч харж байгаагүй юм байна.” гэж Сараа хэлэв.

“Юу л даа, би үргэлж чамтай хамт байсан. Би сэтгэл зүрхнээс чинь гараад ирлээ шүү дээ.” гэж Арио хэлэв.

“Хөөх! Чи надтай хамт байгаа юм чинь дэлхийн бүх хүүхдэд корона вирусийн тухай хэлж чадах нь ээ! Би баатар болж чадах нь!” гэж Сараа хэлэв.

“Гэхдээ, Арио, байзаарай! Корона вирус тархсан ийм үед ийш тийш явбал аюулгүй гэж үү?”





Сараа Ариогийн нуруун дээр суугаад, ерөөнийхөө цонхоор шөнийн тэнгэрт дүүлэн нислээ. Тэд оддын зүг нисэж, замдаа сартай мэндчилэв.

Өглөө нар мандахад тэд пирамидын хажууд үзэсгэлэнт элсэн цөлд тоглож буй цөөн хүүхдийн ойр буув. Хүүхдүүд Сараа, Арио хоёрыг хараад баяртай мэндчилж байлаа.

“Манай улсад тавтай морил! Намайг Салем гэдэг. Та хоёр энд юу хийж байгаа юм бэ? Даанч бид та хоёрт ойртож очиж чадахгүй нь, уучлаарай. Бид бусдаас дор хаяж 2 метр зайтай байх ёстой!” гэж нэг хүү хэллээ.

“Тийм болохоор бид энд ирсэн юм” гэж Сараа хариулаад, “Намайг Сараа гэдэг, харин энэ бол Арио. Хүүхдүүд бид аав ээж, өвөө эмээ, найзууд, хөршөө корона вирусээс хамгаалж чадна гэдгийг мэдэх үү?...”

“Бид мэднэ ээ. Гараа савандаж угаана! Бас ханцуй руугаа ханиана. Хүмүүстэй гар барихгүй, холоос гараараа даллаж мэндчилнэ. Бид аль болох гэртээ байх ёстой. Гэхдээ манай хот их олон хүнтэй. Хүн бүр гэртээ байж чадахгүй байгаа.” гэж Салемийг хэлэхэд Арио, “Аан, тэгвэл би та нарт тусалж чадах байх шүү. Хүмүүс вирусийг харж чадахгүй ч намайг харж чадна! Миний далавчнууд 2 метр зайтай болохоор та хоёр нэг нэгээрээ суучих! Энд аюулгүй.” гэв.



Арио Сараа, Салем хоёрыг суулгаад хотын дээгүүр нисэж, гудамжинд байсан хүүхдүүд рүү хандан ингэж хашхирлаа:

“Гэртээ байвал бид аюулгүй байх болно! Гэртээ байснаараа бид бие биенээ хамгийн сайн анхаарч халамжилж байгаа юм шүү!”

Хүмүүс тэр гурвыг хараад их гайхсан ч тэдэнтэй гараа даллан мэндчилээд, хэлсэн үгийг нь дагаж гэр гэртээ оржээ.





Арио тэнгэр өөд нисэж, Салем баяртайгаар хашхирч байв. Гэтэл үүлэн дунд онгоц нисэж явааг харлаа. Онгоцон доторх хүмүүс тэднийг гайхан харав. “Хүмүүс ийш тийшээ аялж, гадуур явахаа түр болих хэрэгтэй,” гэж Салем хэлэв. “Дэлхий даяар улс орнууд хилээ хааж байна, хүн бүр дотны хүмүүстэйгээ нэг газар байх хэрэгтэй.”

Сараа: “Олон зүйл өөрчлөгдсөн юм шиг надад санагдаж байна. Тийм болохоор би заримдаа энэ вирусээс айдаг.” гэлээ.

Харин Арио түүнд, “Сараа, бидний эргэн тойрны зүйл өөрчлөгдөхөд бид айж, яахаа мэдэхгүй болдог. Тэр чинь зүгээр ээ. Би лав айх үедээ амьсгалаа удаан аваад, амьсгалаа буцааж гаргахдаа гал гаргадаг.” гэж Арио хэлээд амнаасаа томоос том галан бөмбөг гаргав. “Харин та хоёр айхаараа яаж зүгээр болдог вэ?” гэж далавчин дээр сууж яваа найзуудаасаа асуулаа.



“Намайг тайвшруулдаг хэн нэгний тухай би бодох дуртай.” гэж Сараа хэлэв.

“Би ч бас, өвөө эмээ гээд надад сайхан санагддаг, намайг аюулгүй тайван байлгадаг хүмүүсийн тухай боддог.” гэж Салем санал нэгдлээ. “Би тэднийгээ санаж байна. Корона вирусээс хамгаалахын тулд тэднийгээ тэвэрч чадахгүй байгаа. Өмнө нь амралтын өдөр болгон уулздаг байсан бол харин одоо тэднийг хамгаалж, аюулгүй байлгах хэрэгтэй.”

“Чи тэдэнтэй утсаар ярьдаг уу?” гэж Сараа найзаасаа асуув.

“Тийм ээ! Өвөө, эмээ маань өдөр бүр бидэнтэй утсаар ярьдаг. Би гэртээ болсон бүхнээ тэдэнд ярьдаг. Ингэж утсаар ярихад надад гоё санагддаг, тэд маань ч баяртай болдог.” гэж Салем хариуллаа.

“Хайртай дотно хүмүүстэйгээ уулзахгүй байх үед тэднийгээ санах нь хэвийн зүйл юм шүү.” гэж Арио хэлэв. “Ингэж санаж байгаа нь бид тэдэндээ хичнээн их санаа тавьдгийг харуулж байгаа хэрэг. Ингэхэд та хоёр өөр баатруудтай уулзвал гоё уу?”

“Тиймээ, ёстой гоё!” гэж Сараа, Салем хоёр баяртайгаар хариулав. “Гайхалтай! Манай найз Саша үнэхээр супер хүч чадалтай, хэдүүлээ түүн дээр очигцоо.” гэж Арио хэллээ.





Ингээд тэд цааш нисэж, нэгэн жижиг тосгонд газардлаа. Тэнд нэг охин гэрийнхээ гадаа цэцэг түүж байв. Охин Арио болон түүний далавчин дээр суусан хоёр найзыг хараад инээд алдан угтлаа.

“Арио! Одоо бид хоорондоо дор хаяж хоёр метрийн зайтай байх ёстой. Тийм болохоор чамд эндээсээ тэврэлт илгээе! Та нар ямар хэргээр ирэв дээ?” гэж охин чангаар асуулаа.

“Саша, чиний илгээсэн тэврэлтийг баяртайгаар хүлээж авлаа. Хүн үгээрээ, үйлдлээрээ бусдад анхаарал халамжаа харуулахад би үнэхээр дуртай. Найзууд маань чиний супер хүч чадлаас сураасай гэж би хүссэн юм.” гэж Арио хэлэв.

“Надад супер хүч байгаа гэж үү?” гэж Саша Ариогоос асуув.

“Гэр бүлийн чинь нэг хүн өвдөхөд чи корона вирусийг тараахгүйн тулд гэртээ үлдэж чадсан. Чиний супер хүч тэгж бий болсон шүү дээ.” гэж Арио хэлэв. “Тиймээ, манай аав корона вирусээр өвдсөн юм. Аав маань бүрэн эдгэртлээ унтлагынхаа өрөөндөө л байсан.” гэж Саша хэлэв.



“Гэхдээ надад гэрээсээ гарахгүй байх тийм ч хэцүү биш байгаа. Бид гэртээ тоглож, хоол хийж, гэрийнхээ гаднах жижиг цэцэрлэгт түр гарч байгаа. Заримдаа сургуулиа их санадаг болохоор гэртээ хичээлээ хийж, ном уншиж байгаа. Гэртээ байх эхэндээ эвгүй байсан ч одоо зүгээр болсон.”

“Гэртээ хайртай хүмүүстэй хөгжилдөж, харилцаа холбоотой байх аргыг олсон нь сайн байна, Саша. Ийм учраас чи миний баатар болж байгаа юм.” гэж Арио хэллээ.

“Чи гэрийнхэнтэйгээ муудалцаж байна уу?” гэж Салем асуув. “Заримдаа бид жаахан мууддаг. Гэхдээ бид өмнөхөөсөө илүү тэвчээр гаргаж, бие биеэ ойлгохыг хичээж, уучлалт гуйж байгаа. Ингэхээр бид бүгдэд сайхан байдаг. Тийм болохоор би үүнийг супер хүч чадал гэж бодож байгаа. Хааяа би ганцаараа баймаар санагддаг. Тэр үедээ би өөртөө зориулж дуу дуулж, бүжиглэдэг. Заримдаа найзуудтайгаа утсаар ярьдаг...” гэж Саша хариулав.

“Гэвч гэрээсээ хол байгаа, гэр оронгүй хүмүүс яах болж байна, Арио?” гэж Сарааг асуухад Арио: “Маш зөв асуулт байна, Сараа. Хамт тэдгээр хүмүүсийг хайж олъё” гэлээ.





Ингээд тэд Сашад баяртай гэж хэлээд цааш хөдлөв. Явсаар далайгаар хүрээлэгдсэн дулаан цаг агаартай нэгэн арал дээр буужээ.



Тэнд дүүрэн хүнтэй хуаран байв. Нэг охин тэднийг холоос хараад гар даллан мэндчилэв.

“Сайн уу Арио? Чамтай дахиж уулзаж байгаадаа баяртай байна. Бид 2 метрийн зайтай байхыг хичээж байгаа болохоор эндээс ярилцъя. Танай найзуудтай танилцаж болох уу? Намайг Лейла гэдэг.” гэж охин чангаар хашхирлаа.

“Сайн уу Лейла. Намайг Сараа, түүнийг Салем гэдэг. Чи корона вирусээс өөрийгөө хамгаалахаар хичээж байгаа юм байна. Өөр юу хийж байгаа вэ?” гэж Сараа асуув.

“Бид савантай усаар гараа угааж байгаа.” гэж Лейла хариуллаа. “Та нар бас ханцуйдаа ханиаж, найтааж байгаа юу?” гэж Салем асуув. “Надад заагаад өгөөч?” гэж Лейлаг хэлэхэд, Салем түүнд ханцуй руугаа яаж ханиаж, найтаахыг зааж үзүүлэв.

“Бид зоригтой байхыг хүсэж байгаа ч би маш их санаа зовж байгаа. Энэ тухайгаа та нарт ярьж болох уу? Вирусээр өвдөөд нас барсан нэг хүний тухай сонсоод би маш их айсан. Корона вирусээс болж хүмүүс нас бардаг гэж үнэн үү?” гэж Лейла асуулаа.



Арио гүнзгий санаа алдаад доош суув. “Тийм ээ, бяцхан баатрууд минь. Энэ их хачирхалтай зүйл болоод байна.” гээд үргэлжлүүлэн “Зарим хүмүүс огт өвдөхгүй байхад, зарим нь өвдөж, зарим нь нас барж ч магадгүй. Өндөр настай болон өөр өвчтэй хүмүүс энэ вирусийг тусвал хүнд өвдөх магадлалтай. Тийм учраас бид тэдэнд илүү анхаарал тавих хэрэгтэй шүү. Бас та нар айж түгших, аюултай санагдах үедээ хамгийн таатай, аюулгүй санагддаг тийм газрыг толгой дотроо төсөөлж бодоорой. Энэ аргыг надтай хамт туршиж үзэх үү?” гэж Арио асуув.

Бүгд зөвшөөрсөн тул Арио хүүхдүүдийг нүдээ анихыг хүсээд өөрт нь тайван, аюулгүй, сайхан санагддаг газрыг төсөөлөхийг хүслээ. “Тааламжтай, аюулгүй санагдаж байсан үеэ санаарай.” гэж Арио хэлэв. Дараа нь хүүхдүүдээс тэр тайван, аюулгүй, сайхан санагдаж байгаа газартаа юу харж байгаа, ямар санагдаж байгаа болон ямар үнэртэй байгаа талаар нь асуув. Бас энэ гоё газартаа хамт байж, ярилцахыг хүссэн хүн байгаа юу гэж хүүхдүүдээс асуулаа.

“Айж, гуниглахдаа чи төсөөллийнхөө аюулгүй газарт хэзээ ч ирж болно. Энэ бол чиний супер хүч. Үүнийг найз нөхөд, гэр бүлийнхэндээ ч хэлж, хуваалцаж болно. Би чамд санаа тавьж байгааг, бас олон хүн чамд санаа тавьдаг гэдгийг битгий мартаарай. Үүнийг санаж байх нь чамд тустай юм шүү.” гэж Арио хэлэв.



“Бид нар ч гэсэн бие биедээ санаа тавьж, анхаарч чадна шүү дээ.” гэж Лейла хэллээ.

“Яг зөв, Лейла. Бид хаана ч байсан бай, бие биедээ санаа тавьж чадна. Тэгэхээр бидний сүүлийн аялалд чи хамт явах уу?” гэж Арио асуув.

Арио болон түүний найзуудтай хамт аялахыг Лейла зөвшөөрөв. Лейлатай хамт аялах болсонд Сараа баяртай байлаа. Учир нь бие биеэ дэмжих нь ямар чухал гэдгийг Сараа мэдэж байлаа. Тэд юм ярилгүй, чимээгүйхэн нисэж явсан ч шинэ найзууд нь түүнд санаа тавьж буйг Лейла мэдэж байлаа.




Нүдний өмнө цасаар хучигдсан уулс тодорч, Арио жижиг хотод буулаа. Горхины хажууд хэдэн хүүхэд тоглож байв.

“Арио!” гэж тэдний нэг нь хашхиран, гар даллан мэндчилэв.

“Сайн уу, Ким” гэж Арио хариу мэндлээд далавчин дээрээ суулгасан найзууддаа хандаж, “Та нарыг корона вирус тусгаад эдгэрсэн найзуудтайгаа уулзуулья.” гэлээ.

“Өвдөхөд ямархуу байсан бэ?” гэж Салем Кимээс асуув.

“Ханиаж, заримдаа өндөр халуурдаг байсан. Бас би хэд хоног их ядарч, тоглох дургүй болсон. Гэхдээ маш сайн унтаж байсан. Бас гэрийнхэн маань намайг сайн халамжилсан. Бидний зарим ээж аав, эмээ өвөө нар маань өвдөөд, эмнэлэгт хэвтсэн. Эмч, сувилагч нар тэдэнд маш найрсаг хандаж, гэртээ буцаад ирэхэд нь ч хөршүүд, нутгийнхан маань тэдэнд тусалж байсан шүү. Хэдэн долоо хоногийн дараа бид буцаад зүгээр болсон.” гэж Ким хэлэв.



“Би Кимийн найз. Ким вирусээр өвдөж, бид нэг хэсэг уулзаж чадаагүй ч гэсэн бид найзлахаа болиогүй. Би ямар ч үед найздаа санаа тавьж байна. Одоо Ким эдгэрээд, бид хоёр дахин тоглож байгаа, ёстой гоё байна.” гэж нэг хүүхэд ярив. “Ийм үед найзуудын хувьд хийж чадах хамгийн чухал зүйл бол түр хугацаанд тусдаа байж, бие биеэ хамгаалах юм шүү.” гэж Арио хүүхдүүдэд захиж хэллээ.



“Ийм зүйлүүдийг бид ч бас бие биеийнхээ төлөө хийж чадна.” гэж Лейла хэлэв. Харин Салем: “Нэг л өдөр бид урьдын адил хичээл сургуульдаа явж, хамтдаа тоглоно доо.” гэлээ.

Ингээд хүүхдүүд гэр гэртээ харих болжээ. Сараа бүх шинэ найзууддаа баяртай гэж хэлэх цаг боллоо. Тэд энэ гайхалтай аяллыг хэзээ ч мартахгүй гэж бие биедээ амлав. Хэсэг хугацаанд уулзаж чадахгүй байх гэж бодохоор Сараад гунигтай байлаа. Гэвч Кимийн найзын хэлсэн үгийг санахаар түүнд сайхан байв. Хүмүүсийг харж, тэдэнтэй уулзаж чадахгүй гээд тэднийг хайрлахаа болино гэсэн үг биш шүү дээ.



Арио найзуудаа гэр гэрт нь буулгав. Эцэст нь Сараагийн буцаж ирээд, түүний унтахыг хүлээн хажууд нь суужээ.

“Маргааш бас ингэж аялж болох уу?” гэж Сараа Ариогоос асуув.

“Үгүй дээ, Сараа. Одоо чи гэр бүлтэйгээ хамт байж, тэдэнтэйгээ цагаа өнгөрүүлэх хэрэгтэй. Бидний адал явдалт түүхийг санаж байгаарай. Гэртээ байж, гараа угааснаар чи хайртай хүмүүсээ аюулгүй байлгаж чадна. Би чамас холдохгүй ээ. Чи төсөөллийнхөө тайван, аюулгүй газраа очих бүрт чинь би тэнд байж байна.” гэж Арио хэлэв.

“Чи бол миний баатар” гэж Сараа шивнэв.

“Чи ч бас миний баатар, Сараа. Бас чи өөрийнхөө хайртай дотнын бүх хүмүүсийн баатар нь юм шүү.” гэж Арио хариу хэллээ.



Сараа удалгүй унтчихжээ. Маргааш өглөө нь сэрэхэд Арио явсан байлаа. Тэр аяллын турш харсан, сурч мэдсэн бүхнээ цаасан дээр зурав. Адал явдлынхаа тухай ярихаар ээждээ гүйн очиж, зурсан зургаа үзүүлэв.

“Ээж ээ, хүмүүсийг вирусээс хол, аюулгүй байлгахад бид бүгдээрээ тусалж чадна. Би аяллынхаа турш олон баатартай уулзсан.” гэж ярив.

“Өө тэгэлгүй яах вэ, Сараа! Чиний зөв. Эмч, сувилагч гээд хүмүүсийг корона вирусээс хамгаалах олон гайхалтай баатрууд байгаа. Тэднээс гадна бид бүгдээрээ өдөр бүр баатар байж чадна гэдгийг чи надад санууллаа. Миний хамгийн супер баатар бол чи юм шүү!” гэж ээж нь Сараад инээмсэглэн хэллээ.

